



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2022 оны 11 сарын 30 -ны өдөр

Дугаар А/108

Эрдэнэт

**Орон тооны бус мэргэжлийн салбар зөвлөл
байгуулах тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль 6 дугаар зүйлийн 6.2.6, 6.2.7, 6.2.10 заалт, Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/103 тоот тушаал “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого” 2020-2026 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Орхон аймгийн Эрүүл мэндийн газрын дэргэдэх “Эм зүйн чанар, аюулгүй байдал, тусламж үйлчилгээ”-г хариуцсан орон тооны бус мэргэжлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. “Эм зүйн чанар, аюулгүй байдал, тусламж үйлчилгээний орон тооны бус мэргэжлийн салбар зөвлөл”-ийн жилийн ажлын төлөвлөгөөг батлуулж, хэрэгжүүлж ажиллахыг зөвлөлийн дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж удирдлага арга зүйгээр ханган ажиллахыг Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтэс /Б.Уртнасан/-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.СҮХЭЭ

Эрүүл мэндийн газрын даргын 2022 оны
11 дүгээр сарын 30 ны өдрийн
дугаар тушаалын I хавсралт



Орхон аймгийн Эрүүл мэндийн газрын дэргэдэх “Эм зүйн чанар, аюулгүй байдал, тусламж үйлчилгээ”-г хариуцсан орон тооны бус мэргэжлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүн

Дарга:	Н.Амаржаргал	Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Эм зүйн албаны дарга
Гишүүд:	Ж.Уламбаяр	Эм холбооны Орхон аймаг дахь салбарын тэргүүн, Мөнгөнжин эмийн сангийн эрхлэгч
	Э.Золзаяа	“Монос орхон фарм” ХХК-ны ерөнхий менежер
	Ш.Болортунгалаг	Болор инушка ХХК-ны “Царгас фарм” 2-р зэрэглэлийн эмийн сангийн эрхлэгч
	Л.Баттогтох	“Эрдэнэт медикал” төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн эм зүйн албаны дарга
	У. Золзаяа	“Тайхар” дотор уламжлалтын клиникийн эмнэлгийн эм зүйч

Нарийн бичгийн дарга:

О.Анхбаяр ЭМГ-ын Эмийн бодлогын хэрэгжилт, чанар, аюулгүй байдал, зохистой хэрэглээ хариуцсан мэргэжилтэн

Эрүүл мэндийн газрын даргын 2022 оны 11 сарын
20 өдрийн 1/108 тоот тушаалын хоёрдугаар хавсралт



САЛБАР ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1. Орхон аймгийн Эрүүл мэндийн газрын дэргэдэх “Эм зүйн чанар, аюулгүй байдал, тусламж үйлчилгээ”-г хариуцсан орон тооны бус мэргэжлийн салбар зөвлөл /цаашид салбар зөвлөл гэх/ нь мэргэжлийн чиглэлийн бодлогыг тодорхойлох, холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг боловсруулахад оролцох шаардлагатай бусад асуудлыг хэлэлцэх санал, дүгнэлт гаргаж, орон нутгийн хэмжээнд эм зүйн тусламж үйлчилгээний чанарын удирдлагын нэгдсэн тогтолцоог хангах, удирдан зохион байгуулах, эрүүл мэндийн байгууллагын эм зүйн болон эм ханган нийлүүлэх байгууллага, эмийн сангийн үйл ажиллагаа, стандартыг сайжруулах, байгууллагуудын хамтын харилцааг хангахад оршино.
- 1.2. Салбар зөвлөл нь дарга, нарийн бичгийн дарга, гишүүд бүхий 5-7 хүний бүрэлдэхүүнтэй байх ба дараах шалгуурыг баримтална. Үүнд: Тухайн мэргэжлээрээ нэр хүндтэй, салбартаа хүлээн зөвшөөрөгдсөн байх, мэргэжлээрээ 3 ба түүнээс дээш жил ажилласан туршлагатай эм зүйч, эм найруулагч /байж болно./ байх бөгөөд бүрэлдэхүүнийг Эрүүл мэндийн газрын даргын тушаалаар томилж, чөлөөлнө.
- 1.3. Салбар зөвлөлийн үйл ажиллагааны хэлбэр нь хурал байна. Гишүүдийн олонх нь ирсэн тохиолдолд мэргэжлийн зөвлөлийн хурлыг хүчинтэйд тооцно.
- 1.4. Салбар зөвлөлийг улиралд нэг удаа ээлжит, шаардлагатай тохиолдолд ээлжит бус хуралдаан зарлаж хуралдуулах бөгөөд хуралд бүгд санал өгөх эрхтэйгээр оролцох бөгөөд хурлаас гарсан шийдвэр, зөвлөмжийг олонхын саналаар баталж, мэргэжлийн зөвлөлийн даргын гарын үсэг зурж баталгаажуулна.
- 1.5. Салбар зөвлөлийн тайланг гаргаж жил бүрийн 12 дугаар сарын 20-ны дотор Эрүүл мэндийн газрын Хяналт шинжилгээ үнэлгээ, мэдээллийн хэлтэст ирүүлж архивт хүлээлгэн өгнө.

Хоёр. Салбар зөвлөлийн чиг үүрэг

- 2.1. Салбар зөвлөл нь үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтлан ажиллана.
 - 2.1.1. Хууль тогтоомжийг эрхэмлэн дээдлэх
 - 2.1.2. Ил тод байх

2.1.3. Харилцан зөвшилцөх

2.1.4. Тэгш, шудрага байдлыг хангах.

2.2. Тухайн мэргэжлийн хөгжлийн чиг хандлага, тэргүүлэх чиглэлийг тодорхойлох , эм зүйн тусламж, үйлчилгээний эрх зүйн орчинтой холбоотой хэрэгжиж байгаа холбогдох хууль, Эрүүл мэндийн сайдын тушаал, журам, стандартыг хэрэгжүүлэн ажиллах, боловсронгуй болгоход дээд шатны байгууллагууд санал өгөх, хэрэгжилтийг ханган ажиллах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх

2.3. Салбар зөвлөлийн ажлын албаны үүргийг Орхон аймгийн эм зүйн тусламж үйлчилгээний чиглэлийн эрүүл мэндийн байгууллагууд гүйцэтгэнэ.

2.4. Эм зүйн байгууллагуудын мэргэжилтнүүдийг чадавхжуулах, сургалт, туршлага солилцох уулзалт, аяныг зохион байгуулна.

2.5. Бусад нийгэмлэг, мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах, төсөл хөтөлбөр санаачлах.

Гурав. Удирдлага зохион байгуулалт

3.1. Салбар зөвлөлийн даргын эрх, үүрэг

3.1.1. Бусад байгууллага, албан тушаалтны өмнө тухайн мэргэжлийн салбар зөвлөлийг төлөөлөх.

3.1.2. Салбар зөвлөлийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөг хэлэлцүүлж Эрүүл мэндийн газрын даргаар батлан хэрэгжилтийг зохион байгуулж хяналт тавих.

3.1.3. Салбар зөвлөлийн хурлын товыг тогтоож хэлэлцэх асуудлын төлөвлөгөө, хурлын дэгийг батлах.

3.2. Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргын эрх, үүрэг

3.2.1. Салбар зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудлын материалыг бэлтгэх, гишүүдэд урьдчилан хүргэх

3.2.2. Эм зүйн байгууллагууд, нэгж албадын мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалт, туршлага солилцох уулзалт, аяны удирдамжийг гаргаж Эрүүл мэндийн мэндийн газрын даргаар батлуулах

3.2.3. Хурлын протоколыг хөтлөх

3.2.4. Холбогдох асуудлаар гарсан зөвлөмжийг салбаруудад хүргэх

3.3. Салбар зөвлөлийн гишүүдийн эрх, үүрэг

3.3.1 Салбар зөвлөлийн даргын шийдвэрээр мэргэжлийн зөвлөлийг төлөөлж ажлын хэсэгт орж ажиллах.

3.3.2. Салбар зөвлөлийн хурлыг таслахгүй байх, зохион байгуулж буй арга хэмжээнд идэвхтэй хамрагдах.

3.3.3. Эм зүйн салбарт тулгамдаж буй асуудал болон тусламж үйлчилгээнд шинэ санаа, дэвшилтэд технологийг нэвтрүүлэх талаар санал дэвшүүлж мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх

5.1 Дараах зүйлсийг хориглоно.

5.1.1. Хууль эрх зүйд зааснаас бусад үйл ажиллагаа явуулах.

5.1.2. Шалтгаангүйгээр хуралд оролцохгүй байх.

5.1.3. Салбар зөвлөлийн гишүүд мэргэжлийн болон хувийн ёс зүйгүй байх

--000--